

“МОНОС ХҮНС” ХК-ИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2020 оны 02 сарын 18-ны өдөр

№ 03/02
.../.../...

Улаанбаатар хот

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит
хурлыг зарлан хуралдуулах тухай

Компанийн тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.4, 59.10, 59.11, 60 дугаар зүйл, 64 дүгээр зүйл, 65 дугаар зүйл, 71-р зүйл, 76-р зүйлийн 76.1.2, Санхүүгийн зохицуулах хорооны “Хувьцаат компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын зар хүргэх журам”, Компанийн дүрмийн 6-р зүйлийн 6.4, 7.1.2 заалтууд болон 2020 оны 02 дугаар сарын 18-ны өдрийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн хурлын тэмдэглэлийг үндэслэн ТОГТООХ нь:

1. “Монос хүнс” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг 2020 оны 04 сарын 06-ны Даваа гарагийн 14.00 цагт Улаанбаатар хот, Баянгол дүүрэг, 20-р хороо, Сонсголонгийн зам гудамж, Монос хүнс компанийн ус ундааны шинэ үйлдвэрийн байранд зарлан хуралдуулсугай.
2. Хувьцаа эзэмшигчдийн хурлаар дараах асуудлыг хэлэлцүүлэхээр баталсугай. Үүнд:
 - 2.1. Компанийн 2019 оны санхүүгийн тайланд аудит хийсэн хөндлөнгийн компанийн аудитын дүгнэлтийг танилцуулах,
 - 2.2. Компанийн 2019 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаархи Төлөөлөн удирдах зөвлөлийн дүгнэлтийг хэлэлцэн батлах,
 - 2.3. Хөрөнгө оруулагчдаас татан төвлөрүүлсэн хөрөнгийн зарцуулалтын тайланг танилцуулах,
 - 2.4. Ногдол ашиг хуваарилах тухай Төлөөлөн Удирдах Зөвлөлийн хурлаас гарсан тогтоолыг танилцуулах,
 - 2.5. Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2020 оны төсвийг батлах,
3. Хуралд оролцох эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах бүртгэлийн өдрийг 2020 оны 03 сарын 11-ний өдрөөр тогтоож, “Хувьцаа эзэмшигчдийн хурлын мэдэгдэл”-ийг СЗХ, МХБ-д хууль тогтоомжид заасан хугацаанд хүргэсүгэй.
4. Компанийн хурлын зарыг тогтоолын Хавсралт №01-аар батлан, Монголын Хөрөнгийн Биржийн цахим хуудас, өдөр тутмын хоёроос доошгүй сонин болон телевизээр дамжуулан 2020 оны 02 сарын 21-ний өдөр нийтэд мэдээлж, зарын давталтыг 2020 оны 03 сарын 06-ны өдөр анх зарласан хэлбэрээр дахин нийтэд мэдээлсүгэй.
5. Хурлаар хэлэлцэх асуудал, түүнтэй холбогдох баримт бичигтэй ажлын өдрүүдэд 10:00-16:00 цагийн хооронд Хан-Уул дүүргийн 2 хороо, Монос хүнс үйлдвэрийн байранд ирж танилцах боломжтой болохыг мэдээлсүгэй.
6. Хурлын саналын хуудсыг энэ тогтоолын Хавсралт №02-оор батлаж, хуралд биечлэн оролцох боломжгүй хувьцаа эзэмшигчдээс саналын хуудсаар санал авах сүүлчийн

- хугацааг 2020 оны 03 сарын 27-ны өдрөөр тасалбар болгож саналын хуудсыг брокер дилерийн компаниуд болон компанийн байранд хүлээн авахаар тогтоосугай.
7. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын даргаар ТУЗ-ийн хараат бус гишүүн Б.Гантулгыг томилсугай.
8. Дараах нэр бүхий хүмүүсийг Хурал зохион байгуулах комиссын бүрэлдэхүүнээр томилсугай. Үүнд:
- 8.1.Хурал зохион байгуулах комиссын дарга:
Үйл ажиллагаа хариуцсан захирал П.Тодрол
- 8.2.Хурал зохион байгуулах комиссын гишүүд:
ТУЗ-ийн нарийн бичгийн дарга Н.Цагаанхүү
Бизнес хөгжлийн албаны дарга Б.Хаш-Эрдэнэ
Маркетингийн албаны дарга Э.Энхтүвшин
Шингэн хүнсний үйлдвэрийн дарга А.Одонгэрэл
Олон нийттэй харилцах менежер Э.Номин
9. Дараах нэр бүхий хүмүүсийг хурлын Тооллогын комиссын бүрэлдэхүүнээр томилсугай.
- 9.1. Тооллогын комиссын дарга:
Санхүүгийн менежер Э.Амарболд
- 9.2.Хурал зохион байгуулах комиссын гишүүд:
Борлуулалтын албаны дарга Б.Бархас
Бизнес аналитст Ц.Дөлгөөнмайдар
10. Хувьцаа эзэмшигчдийг хурлын материалтай танилцах нөхцөл, боломжийг бүрдүүлж, хуралд бэлтгэх, зохион байгуулах бэлтгэл ажлыг ханган ажиллахыг хурал зохион байгуулах комисс (П.Тодрол), Гүйцэтгэх захирал (А.Отгондарь) нарт даалгасугай.

ТУЗ-ИЙН ДАРГА



Л.ХҮРЭЛБААТАР



Өдөр тутмын хэвлэл, мэдээллийн хэрэгсэлд өгөх

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын зар

“Монос хүнс” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн анхааралд

“Монос хүнс” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал 2020 оны 04 сарын 06 өдрийн 14 цагт Улаанбаатар хотын Баянгол дүүрэг 20 хороо Сонсголонгийн зам гудамж хаягт байрлах Монос хүнс компанийн ус ундааны үйлдвэрийн байранд болох тул Хувьцаа эзэмшигчдийг хүрэлцэн ирэхийг урьж байна.

Хуралд оролцох эрхтэй хувьцаа эзэмшигчдийг бүртгэх өдөр: 2020 оны 03 сарын 11

Хурлаар хэлэлцэх асуудал:

1. Компанийн 2019 оны санхүүгийн тайланд аудит хийсэн хөндлөнгийн компанийн аудитын дүгнэлтийг танилцуулах,
2. Компанийн 2019 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаархи Төлөөлөн удирдах зөвлөлийн дүгнэлтийг хэлэлцэн батлах,
3. Хөрөнгө оруулагчдаас татан төвлөрүүлсэн хөрөнгийн зарцуулалтын тайланг танилцуулах,
4. Ногдол ашиг хуваарилах тухай Төлөөлөн Удирдах Зөвлөлийн хурлаас гарсан тогтоолыг танилцуулах,
5. Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2020 оны төсвийг батлах,

Хурлын материал, түүнтэй холбогдох баримт бичигтэй ажлын өдрүүдэд 10:00-16:00 цагийн хооронд Хан-Уул дүүргийн 2 хороо, Монос хүнс үйлдвэрийн байранд ирж танилцах боломжтой.

Хуралд биеэр ирэх боломжгүй хүмүүс 2020 оны 03 сарын 27 өдөр хүртэл харилцдаг брокер, диллерийн компаниар дамжуулах буюу “Монос хүнс” компанийн байранд ирж саналын хуудсаа бөглөн өгөх боломжтой.

Хурлын талаар дэлгэрэнгүй мэдээллийг компанийн байранд болон хурал зохион байгуулах комиссын утсаар холбогдон авна уу.

Хаяг: Хан-Уул дүүрэг, Чингисийн өргөн чөлөө, Мишээл экспо худалдааны төвийн баруун талд
Утас: 99035178, 88080308

ХУРАЛ ЗОХИОН БАЙГУУЛАХ КОМИСС

**МОНОС ХҮНС ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН
САНАЛ АВАХ ХУУДАС**

Хувьцаа эзэмшигчийн овог нэр: _____

Регистрийн дугаар: _____

Эзэмшиж буй хувьцааны тоо (ширхэг) : _____

Бүртгэсэн ҮЦК-ийн нэр: _____

Бүртгэсэн брокерийн овог, нэр: _____

№	Хурлаас гарах шийдвэрийн томъёолол	Зөвшөөрсөн	Татгалзсан	Түдгэлзсэн
1	“Монос хүнс” ХК-ийн 2019 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаархи Төлөөлөн удирдах зөвлөлийн дүгнэлтийг батлах			
2	“Монос хүнс” ХК-ийн ТУЗ-ийн 2020 оны төсвийг батлах			

Санал авах хуудсыг ашиглах санамж:

1. Хувьцаа эзэмшигч нь саналын хуудсыг бөглөхдөө санал өгөх хэсэгт (+) тэмдэглэгээ хийнэ. Жишээ нь: Зөвшөөрсөн бол зөвшөөрсөн гэсэн нүдэнд (+) тэмдэг гэхчилэн тавина.
2. Саналын хуудсыг балласан, засварласан, тэмдэглэгээ хийгээгүй бол хүчингүйд тооцно.
3. Хувьцаа эзэмшигч нь өөрийн биеэр хуралд оролцож чадахгүй бол үнэт цаасны компани дээр очиж хурлын материалтай танилцан, саналын хуудсаа бөглөж 2020 оны 03 сарын 27 өдрөөс өмнө хүргүүлэх боломжтой.
4. Хэрэв өөр хүнээр төлөөлүүлэх бол тухайн төлөөлөх хүнд итгэмжлэл олгож нотариатаар баталгаажуулсан байх ба уг итгэмжлэл нь зөвхөн тухайн хурлын өдөр хүчинтэй байна.

Хувьцаа эзэмшигчийн гарын үсэг _____ /_____/_____

Саналын хуудсыг хүчинтэй/ хүчингүйд тооцсон:

Хүчингүйд тооцсон бол шалтгаан: _____

Тооллогын комиссын дарга: _____

Гишүүд: _____

СЗХ-ны 2018 оны 12 дугаар сарын 14-ний өдрийн
377-р тогтоолоор баталсан “Хувьцаат компанийн хувьцаа
эзэмшигчдийн хурлын зар хүргэх журам”-ын нэгдүгээр хавсралт

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН МЭДЭГДЭЛ

Компанийн нэр:	МОНОС ХҮНС ХК
Хаяг:	ХУД, Чингисийн өргөн чөлөө, 205/2 тоот
Хурал хуралдах өдөр, цаг:	2020 оны 04 сарын 06, 14:00 цагт
Хурал хуралдах газар /хаяг, байршил/:	БГД, 20-р хороо, Сонсголонгийн зам гудамж, Монос хүнс шинэ үйлдвэрийн байранд
Хурлын төрөл:	Ээлжит
Хурал зарлагч:	ТУЗ
Хурал хуралдах шийдвэр гаргасан огноо:	2020 оны 02 сарын 18
Олон нийтэд зарлах огноо:	2020 оны 02 сарын 21
Бүртгэлийн өдөр:	2020 оны 03 сарын 11
Хурлын баримт бичгийг БДК-д хүргүүлэх огноо:	2020 оны 03 сарын 06
Хүргүүлсэн огноо:	2020 оны 03 сарын 06
Хурлын даргын нэр:	ТУЗ хараат бус гишүүн Б.Гантулга
Тооллогын комиссын дарга, гишүүдийн нэр:	Дарга Э.Амарболд Гишүүд Б.Бархас, Ц.Дөлгөөнмайдар
Баримт бичгийн жагсаалт	1. Монос хүнс ХК-ийн ХЭ-ийн ээлжит хурлыг зарлан хуралдуулах тухай ТУЗ-ийн 2020-02-18 өдрийн тогтоол 2. ХЭ-ийн хурлын зарын загвар 3. Монос хүнс ХК-ийн 2019 оны үйл ажиллагааны тайлан 4. Монос хүнс ХК-ийн 2019 оны санхүүгийн аудитлагдсан тайлан 5. Монос хүнс ХК-ийн ТУЗ гишүүдийн танилцуулга 6. Компанийн ТУЗ-ийн 2020 оны төсвийн санал 7. Компанийн болон бүтээгдэхүүний танилцуулга /товхимол/ 8. ХЭ-ийн хурлын дэг 9. ХЭ-ийн хурлын саналын хуудас 10. ХЭ-ийн хурлаас гарах шийдвэрийн төсөл
Баримт бичгийн хуудасны тоо:	 7 хуудас

ХУРАЛ ЗОХИОН БАЙГУУЛАХ КОМИССЫН ДАРГА

МОНОС ХҮНС
ХК

/П.ТОДРОЛ/

2020 оны 04 сарын 18 өдөр

“МОНОС ХҮНС” ХК-ИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2020 оны 02 сарын 18-ны өдөр

№/2020

Улаанбаатар хот

Ногдол ашиг хуваарилах тухай

Компанийн тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1, 46.2 заалт, 76 дугаар зүйлийн 76.1.12 заалт, “Монос хүнс” ХК-ийн дүрмийн 11 дүгээр зүйлийн 11.5, 11.6 заалтууд болон 2020 оны 02 дугаар сарын 18-ны өдрийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Монос хүнс” ХК-ийн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд тусгагдсан цэвэр ашгаас нэгж хувьцаанд 1 (нэг) төгрөгөөр тооцон, нийт 408,850,428 (дөрвөн зуун найман сая найман зуун тавин мянга дөрвөн зуун хорин найм) төгрөгийн ногдол ашиг хуваарилахыг зөвшөөрсүгэй.
2. Ногдол ашиг авах эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах өдрийг 2020 оны хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд оролцох эрхтэй хувьцаа эзэмшигчдийг бүртгэх бүртгэлийн өдрөөр тогтоосугай.
3. Энэхүү тогтоолын хэрэгжилтийг хангаж хувьцаа эзэмшигчдэд ногдол ашиг тараах ажлыг Үнэт Цаасны Төвлөрсөн, Хадгаламжийн Төвтэй байгуулсан гэрээний үндсэн дээр 2020 оны 08 сарын 31-ний өдрөөс эхлэн тарааж гүйцэтгэхийг Гүйцэтгэх захирал (А.Отгондарь)-д даалгасугай.
4. Энэхүү тогтоолын хэрэгжилтэнд хяналт тавих, ногдол ашиг тараах мэдээллийг зохих журмын дагуу хувьцаа эзэмшигчдэд хүргэхийг ТУЗ-ийн нарийн бичгийн дарга (Н.Цагаанхүү)-д үүрэг болгосугай.

ТУЗ-ИЙН ДАРГА



Л.ХҮРЭЛБААТАР